

Шанжмятав Гаадамба

Ш.Гаадамба бид нэг их ойр дотносож яваагүй, уг нь бол эцгийн талын садан сүлбээтэй юм билээ. Тэрээр 1940-өөд оны дундуур Булган аймгийн 7 жилийн дунд сургуульд дунд ангийн багш, би бага ангийн сурагч, 1950-иад оны дундуур биднийг МУИС-д сурч байхад монголын уран зохиол зааж байсан багш маань юм. Ном заалгаж, бүтээлийг нь сонирхож, судалж байсан шавь нэг нутгийн хүний хувьд Халзан багшийг нутгийнхаа үеийн нөхөд миний багш Д.Доржсүрэн, А.Балчиндорж нарын зэрэг хүмүүстэй уулзаж ярилцаж байхад нь хаа нэг хажуу хавирганд нь байж, түүний амьдралын сүүлийн 10-аад жилд мөн л хаа нэг түр зуурхан учирч цаг төрийн байдал, таних, "танихгүй" зарим хүмүүсийн мэдлэг чадвар, бүтээл ноён нуруу, төрх төлөвийн тухай санаж бодсоноо бие, биеийнхээ амыг дагахгүйгээр ил шууд хэлэлцэж явлаа. Нэг мэргэн хүн: хэрвээ бид алим солилцвол хүн бүр нэг л алимтайгаа үлдэнэ, харин санаа бодлоо солилцвол хүн бүрт л харилцагчийн тоогоор төдий чинээ санаа бодол төрнө гэсэн байдаг. Ерөөс санаа бодлоо солилцох, ялангуяа анги, тусгай ухааралтай хүмүүстэй санаа солилцох нь их олз байдаг бол уу. Бага, дунд, их сургуульд сурч байхад олон багш нар эрдэм зааж, бие сэтгэлээрээ үлгэрлэн нөлөөлж ном эрдэмд шамдан сурахын үнэнлэг, хүмүүнлэг шим, ач өгөөж хийгээд нүгэлгүй, зүйтэй амьдрах ухаан, нөхөрт болон өрөөс хүнд гай тарихгүй, бас өөрийгөө өртөөс, золиос болгохгүй байх арга адармаа олгох зэргээр сургаж хүмүүжүүлсэнийг би ямагт ачлан бодож явдаг юм. Тэдгээр 100 гаруй багш нараас Ш.Гаадам ба, дам ар хочтой Дорж, Ч.Лодойдамба агсан гурван багш миний мунхаг ухаанд нэг л содон үлдсэн байдаг юм.

Ш.Гаадамба багш сурган хүмүүжил, эрдэм судлалын хийгээд уран бүтээлийн ажлаараа бидний гадарлах түүний үеийн газар, газрын олон нөхдөөсөө нэг л анги, гойд содон хүн байсан. Энэ тухайн эрэгцүүлээ ялихгүй, цөөн зүйлээр тодруулахыг оролдоё. Нэг. Тэрээр Булган аймгийн төвийн дунд сургуульд багшилж байхдаа номтой нөхөрлөж өөрийгөө боловсруулах ажилд бие, сэтгэлээ өгсөн хүн байсныг миний бие хожуухан л ухаарсан. Тэр үед Халзан багшийн бор гэрээс шөнө дундын үеэр Мандалын хөгжимд ардын дуу эгшиглэж байдаг байсан. Түүнийхээ учрыг нөхөддөө "жаахан юм уншиж, эрэгцүүлээд ирэхээр нойр хулжиж юм бодоод тархи толгой ядарчих гээд байх юм гэдэг байсан. Сэтгэдэг материйг ачаалалтай байлгаж, үндсэн үүргийг нь хангалттай гүйцэтгүүлэхийн хамт, сэхээтэн авч явах тухай тээр 1940-өөд оны үед ухаарч, сэргийлэх ажил хийж байсан манай цөөхөн хүмүүсийн нэг бол уу. Хоёр. Ш.Гаадамба уран зохиолын онолын судалгааны тухайд манай орны товойн тодорч гарсан том эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч хүн. Ийм үнэлгээг тэрний бүтээл даахаас гадна, түүний унаган шавь нар зөвшөөрнө. Уран зохиолын онолын суурь мэдлэгтээ тулгуурлан нууц товчооны судалгаагаар түүний бүтээсэн бүтээлүүд манай хийгээд дэлхийн м онгол судлаачдын хайр талархалыг татаж, урам зоргийг хөгжөөж, дур хүслийг булааж байна. XIII зууны үед туурвигдсан "Монголын нууц товчоо" өнөөдөр монголын түүх, соёлын төдийгүй дэлхийн түүх, соёлын ховор нандин эрдэнс юм. Хүн төрөлхтөнд ийм бүтээл туурвин үлдээсэн монгол зохиогчийн хүмүүнлэгийн м эдлэг, чадвар, ур ухаан, бүтээлч чанарыг Ш.Гаадамба бас нээсэн нь түүний бас нэг гавъяа буюу. Гурав. Ш.Гаадамба багшийн уран бүтээлийн нэг содон, бас төгөлдөр хандлагатай шинж бол хэвшмэл бодрол, арга бодлоос эрс татгалзаж, уян нялархай буюу уянгын аргаар с этгэн асуудлыг янз бүрээр тэндээ үнэн зөв шийдэх ухаарал төрүүлэх чиглэлтэй байдаг явдал мөн. Энэ нь ч түүний төрмөл анги шинж, онолын их мэдлэг, түүнээ хэрэглэх ур чадварын давуу талтай холбоотой бол уу. Хүн болгон адилгүй, хүлэг болгон төрөөгүй гэж үг бий. "Элбэг

дээл", "Чөдөр өвс" зөвхөн энэ хоёр бүтээлийг л үзэхэд тэр цагийн тогтсон бадрал, чиглэл, арга барилаас эрс өөр асуудлыг амьдралаас, хүний дотоод сэтгэлгээнээс судлан авч шийдэн уншигч, судлаач нарыг янз бүрээр сэтгэх, ухаарах хандлагад хөтөлсөн байдаг. Нэгэн бүтээлдээ:

Үхсэн хүний нэрийг

Үр ачид нь дуурсгахаар

Үхээрийн булшин дээр нь

Едор пайз босгох юм гээд миний үзэж байгаагаараа бол бас л нөгөө талаас нь буюу судалгааны аргаар

Мөнгөн цагаан цаасанд

Мөнхийн үнэнийг шингээж

Цагийн бэрхэд идэгдэхгүй

Цагаан гантиг босгоно би гэсэн байдаг юм.

Монгол улсын төрийн соёрхолт эрдэмтэн доктор, зохиолч Шанжмятавын Гаадамба агсаны 70 жилийн сүүдэр дохиож байгаа энэ өдрийн өмнөхөн түүний эрдмийн мөрөө эхэлсэн Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 10 жилийн сургуулийн 70 жилийн ой болсон юм.

Л.Бат-Счир Доктор (Ph.D), профессор